



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/373

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "в", Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит V дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нийтийн эзэмшлийн зам талбай, авто замд үерийн улмаас томоохон хэмжээний эвдрэл гарсан тул авто замын чулуу, модыг зайлуулах, тэгшлэх шаардлагатай байгаа шатахууны зардал болох 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Замын сангийн нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд) нарт зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай

ДАРГА



Л. ГАНБОЛД